



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 11/11

Цагаан-Уул сум

Г Үнэлгээний хороо байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зардлаар хийгдэх Үерийн усны хаялга, гүүр засварын ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга: У.Аварзэд (Засаг даргын орлогч)


Гишүүд: М.Оюунчимэг (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ш.Эрдэнэцэцэг (Санхүүгийн албаны дарга)

2. Ажлын даалгавар боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, захиалагчид танилцуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (У.Аварзэд)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-д даалгасугай.

ДАРГА



С.ГОНЧИГНЯМ